

Маягт СЗХ04008

Даатгалын бүтээгдэхүүний мэдэгдлийн маягт

1	Мэдэгдэл огноо	Он	2021	Сар	03	Өдөр	29
2	Мэдэгдэл гаргагчийн оноосон нэр	Амар Даатгал ХХК					
3	Даатгалын бүтээгдэхүүний нэр	Орон сууцны хариуцлагын даатгал					
4	Даатгалын бүтээгдэхүүний холбогдох даатгалын хэлбэр	Хариуцлагын даатгал					
5	Даатгалын бүтээгдэхүүнийг борлуулах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр	Шийдвэрийн нэр		Огноо		Дугаар	
		Даатгалын бүтээгдэхүүн шинээр батлах тухай		2021-02-26		ЗТ-21/02-044	
6	Цахимаар борлуулах эсэх	Тийм					
7	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Овог		Нэр			
		Доржготов		Уранцэцэг			
Мэдээллийн төрлийг сонгоно уу.							
8	Даатгалын бүтээгдэхүүнийг шинэчлэх						
Даатгалын бүтээгдэхүүний ерөнхий мэдээлэл							
9	Даатгалын зүйл	Гуравдагч этгээдийн эд хөрөнгийн ӨХХ					
	Даатгалын үндсэн эрсдэл	Орон сууцны өмчлөгч, эзэмшигч, түрээслэгчийн санамсар болгоомжгүй үйлдэл					
	Даатгалын нэмэлт эрсдэл						
	Даатгалын хураамжийн хувь, хэмжээ	0.3%-0.8%					

Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Даатгалын багц дүрэмд нийцүүлэн мэдэгдлийг үнэн зөв бөглөж, хүргүүлэв. Дээр мэдэгдсэн зүйл нь ямар нэг худал ташаа зүйл орсон байвал хариуцлагыг бид хүлээх болно.

ДААТГАЛД ХАМРАГДАХГҮЙ НӨХЦӨЛҮҮД

1. Даатгуулагчийн болон түүний зөвшөөрөл бүхий этгээдийн санаатай даатгалын тохиолдол бий болох нөхцөл, орчныг бүрдүүлснээс үүссэн хохирол;
2. Даатгуулагч энэхүү гэрээнд болон хуулинд заасан үүргээ зөрчснөөс үүдэн хохирлын хэмжээ ихэссэн бол ихэссэн хохирлыг;
3. Даатгуулагч даатгалын зүйлийн талаар даатгагчид худал мэдээлсэн, хуурамч бичиг баримт бүрдүүлэхээр завдсан, бүрдүүлсэн нь тогтоогдсон;
4. Энэхүү гэрээнд заасан даатгалын хамгаалалт болон даатгалын гэрээнд хамаарахгүй хохирол;
5. Даатгуулагч даатгалын хураамжийг даатгалын гэрээнд заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд;
6. Даатгалын тохиолдол болсныг даатгуулагч мэдсэнээс хойш 72 цагийн дотор даатгагчид мэдэгдээгүй бол;
7. Нөхөн төлбөрийн нэхэмжлэл гарснаас хойш даатгагч, түүний эрх бүхий этгээдийг даатгалын тохиолдлыг газар дээр нь очиж хохирлын баталжуулалт, үзлэг хийх боломжоор хангаагүй бол;
8. Даатгуулагчийн даатгалын хамгаалалт үйлчилж эхлээгүй, эсвэл дуусгавар болсон үед учирсан хохирол;
9. Даатгуулагч, түүний зөвшөөрөл бүхий этгээд нь гэм буруугийн санаатай болон хөнгөмсгөөр найдсан хэлбэрээр гэмт хэрэг үйлдэхээр завдсан, эсхүл гэмт хэрэг үйлдсэний улмаас өөртөө, гуравдагч этгээдэд болон даатгалын зүйлд хохирол учруулсан;
10. Даатгалын эрсдэлд хамаарахгүй, давагдашгүй хүчин зүйлийн улмаас учирсан хохирол;
11. Дайн болон байлдаан, хувьсгал, булаан эзлэх, барьцаалах, мина бөмбөг дэлбэрэх, терроризм, нийтгийг хамарсан үймээн самуун, хорлон сүйтгэх үйл ажиллагаа зэрэг үйл явдлуудын улмаас үүссэн хохирол;
12. Нийтийн эмх замбараагүй байдал, иргэний бослого, үймээн, баривчлан саатуулах, самуун бослого, ажил хаялт болон улс төрийн шинж чанэртай жагсаал, цуглаанаас үүдсэн хохирол;
13. Цөмийн дэлбэрэлт, байлдааны зэвсэг, цацраг идэвхт бодисоос үүдэлтэй хохирол;
14. Энэхүү гэрээнд болон даатгалын гэрээнд өөрөөр заагаагүй бол даатгалын тохиолдлын улмаас үүдэн гарсан эдийн засгийн хохирол, олох ёстой байсан орлого болон бусад үр дагавар гэх мэт аливаа шууд бус хохирол, зардал;
15. Даатгуулагч, түүний зөвшөөрөл бүхий этгээд согтууруулах ундаа, мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрүүлэн хэрэглэснээс үүдэн гарсан болон хэрэглэсэн үед үйлдсэн үйлдлийн улмаас үүссэн хохирол;
16. Сэтгэл санааны хохирол;
17. Хорлон сүйтгэх, эвдэн сүйтгэх үйл ажиллагаа;
18. Тест хийгдээгүй болон зөвшөөрөлгүй технологийн эрсдэл;
19. Даатгуулагч, түүний зөвшөөрөл бүхий этгээдийн сайн дураараа төлсөн төлбөр, хохирол болон бусдын өмнө хүлээсэн гэрээний нэмэлт үүрэг;
20. Орон сууцандаа засвар хийх явцдаа даатгалын тохиолдол бий болсон эсхүл зориулалтыг өөрчлөх, ашиглалтын горим зааврыг зөрчсөн, даац, бүтээц өөрчлөх, зориулалтын бус тоног төхөөрөмж тавьсан, суурилуулснаас үүдэн гарсан хохирол;

21. Орон сууцны барилга, түүнд суурилуулсан тоног төхөөрөмж болон сантехникийн ээлжит урсгал засвар үйлчилгээг мөрдөгдөж буй “БАРИЛГА АШИГЛАЛТЫН ДҮРЭМ, БАРИЛГЫН НОРМ БА ДҮРМҮҮД” (БНБД)-ийн дагуу хийгээгүйгээс учирсан хохирол;
22. Даатгалын тохиолдол болсноос хойш хуанлийн 90 хоногийн дотор гэрээнд заасан нөхөн төлбөрийн баримт материалыг бүрэн бүрдүүлж өгөөгүй бол;
23. Даатгуулагч орон сууцанд цахилгаан болон сантехникийн хийц, монтажийг анхны хийцийг далдлах болон бусад арга замаар өөрчилснөөс шалтгаалж холбогдох засвар үйлчилгээг стандартын дагуу хийх боломжгүй болсны улмаас үүссэн хохирол;
24. Хууль тогтоомжид заасан бусад үндэслэл;